



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 09 өдөр

Дугаар 5/14

Чингис хот

Баянмөнх сумын цэцэрлэгийн эрхлэгч
Б.Гангантөгсөд сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 4.4, Хөдөлмөрийн тухай хуулийн 131.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 84 дугаартай албан бичгээр ирүүлсэн саналыг харгалзан хүүхдийн сургалтын орчин дахь аюулгүй байдлыг хангах үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн тул Баянмөнх сумын цэцэрлэгийн эрхлэгч Б.Гангантөгсийн үндсэн цалинг 3 сарын хугацаанд 20 хувь бууруулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Албан үүргээ холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд биелүүлж ажиллахыг цэцэрлэгийн эрхлэгч Б.Гангантөгсөд үүрэг болгосугай.

3. Эрхлэгчийн ажлыг мэргэжил арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Боловсрол, соёл, урлагийн газар /С.Мөнхцэцэг/-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Г.Лхагвахатан/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА